



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/381

Ховд

Үндэсний сурын харваа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.28 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоол, аймгийн Үндэсний сурын холбооны хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний сурын харвааг 2021 оны 8 дугаар сарын 6-наас 9-ний өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн Сурын харвааны талбайд үзэгчгүйгээр зохион байгуулсугай.

2. Үндэсний сурын харваа зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Сурын харвааг тогтоосон хугацаанд “Үндэсний болон Урианхай сурын харвааны дүрэм”, холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу Улс, аймгийн Онцгой комиссын шийдвэр, чиглэл, коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн журам, зааврыг чанд мөрдөн үзэгчгүйгээр хариуцлагын гэрээний дагуу өндөр түвшинд зохион байгуулахыг Үндэсний сурын харваа зохион байгуулах комисс /Б.Баярсүх/-т даалгасугай.

4. Сурын харваа зохион байгуулахад коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх ерөнхий болон тусгай журам, зааврын хэрэгжилтэнд хяналт тавьж, харваачдаас коронавируст халдвар /Ковид-19/-ын хурдавчилсан тестээр шинжилгээ авч, сурын харваанд оролцогчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Бүсийн оношилгоо эмчилгээний төв /П.Гэрэлсүрэн/ нарт үүрэг болгосугай.


5. Сурын харвааны үед харуул хамгаалалт болон нийтийн хэв журам сахиулах арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
08 дугаар сарын 02-ны өдрийн
А/381 дүгээр захирамжийн хавсралт



СУРЫН ХАРВАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Гишүүд:
- Ч.Чинбат - Аймгийн Сурын холбооны тэргүүн
- Г.Лхагвасүрэн - Аймгийн Сурын холбооны тэргүүлэгч
- Ч.Түмэндэмбэрэл - Биеийн тамир, спортын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Д. Сумъяа - Аймгийн Сурын холбооны нарийн бичгийн дарга

-оОо-